



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

АГУУЛГА

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар	3
1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар	3
1.3. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар	4
1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар.....	5
1.5. Хяналт шалгалтын талаар	5

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар.....	6
2.2. Хууль, шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар	6

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ:

8

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

8

4.1. Авто замын талаар	8
4.2. Авто тээврийн талаар	9
4.3. Төмөр замын талаар	9
4.4. Агаарын тээврийн талаар	10

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

11

ЗУРГАА. УУЛЗАЛТ, ӨДӨРЛӨГ БОЛОН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР:

11

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛАН

2018 оны 11 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Зам, тээврийн хөгжлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, яамны үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар:

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, яаманд ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариу өгөх хугацаа хэтэрсэн бичгийн мэдээг 7 хоног тутам гаргаж удирдлагуудад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Тус яаманд 2018 оны 10 дугаар сард нийт 912 бичиг ирснээс хариутай 441 бичиг, хариугүй 471 бичиг, шийдвэрлэсэн 284 нийт 14762 хуудас бичгийг сканердаж бүртгэл мэдээллийн санд орууллаа.

Ирсэн бичгийг удирдлагын цохолтоор Бодлого, төлөвлөлтийн газарт-127, Төрийн захиргааны удирдлагын газарт-253, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-140, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-83, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-120, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэст-68, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт-110 бичиг шилжүүлсэн байна. Яамнаас гадагш 560 албан бичиг явуулж 3916 хуудас сканердаж able программд оруулсан.

Явуулсан бичгийг газар тус бүрээр ангилбал: Бодлого төлөвлөлтийн газар-109, Төрийн захиргааны удирдлагын газар-160, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар- 109, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-50, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-64, Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-24, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-44 албан бичиг тус тус явуулсан байна.

1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цаг тухайд нь цахим болон дэвтрээр бүртгэн удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтэс, мэргэжилтэнд шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар яамны хэмжээнд иргэд, албан хаагчдаас нийт 35 өргөдөл, гомдол ирснийг удирдлагад танилцуулан цохолт хийлгүүлж холбогдох албан тушаалтанд хуваарилан ажиллалаа. Шийдвэрлэж хариу өгсөн 26, хяналтад байгаа 9, хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй. Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн хувь 74.29 байна. Дээрх өргөдөл, гомдол нь ээлжийн амралт олгуулах, цалинтай, цалингүй чөлөө хүссэн зэрэг агуулгатай байна.

Иргэд болон албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авах “Санал хүсэлт”-ийн хайрцгийг 1 давхарт байрлуулан санал хүсэлтийг бүртгэх, хүлээн авах албан тушаалтныг томилон тогтмол ажиллуулж байна.

1.4. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар:

Батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийн баталгааг үндэслэн 10 дугаар сард Зам тээврийн хөгжлийн сайд /ТЭЗ/-ын багцын байгууллагуудын нийт 216 ширхэг 11,4 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг “Төрийн сангийн төлбөр тооцооны систем”-д бүртгэн анхан шатны баримттай тулган шалгаж, төсвийн тухай хууль болон холбогдох журам дүрмийн дагуу төлбөр тооцоог хурдан шуурхай, үнэн зөв хийж гүйцэтгэн, хянан баталгаажуулж ажилласан.

Сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн 09 сарын мэдээг харьяа байгууллагуудаас хүлээн авч төсвийн хэлбэлзэлтэй тулган шалгаж программд шивж нэгтгэн Сангийн яаманд 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хүргүүлсэн.

Засгийн газрын шилэн дансны хуудсанд байгууллагын 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ болон Сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд тайлагнасан.

Төсвийн тухай хуулийн 8, 29.4-т заасны дагуу саналаа ирүүлсэн Нийслэл, Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Төв, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Хэнтий, Ховд, Увс, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Говь-Алтай, Булган, Баян-Өлгий, Завхан, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь зэрэг 21 аймаг, Иргэний нисэхийн ерөнхий газар, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Далайн захиргаа, МТЗ “ТӨХК”, Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудын ирүүлсэн төсвийн төслийн саналыг хянан боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЭЗ/-ын багцын 2019 оны төсвийн төслийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/3822, 02/3939 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 9-р сарын 28 ны өдөр 2019 оны улсын төсвийг УИХ-д өргөн барьсан. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240 төсөл”-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2018 оны 4 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсөв, Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 9 дүгээр сарын зардлын гүйцэтгэл болон 4 дүгээр улирлын төсвийг хянаж Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газарт хүргүүлэв.

2018 оны 10 дугаар сарын байдлаар Зам, тээврийн сайдын багцаас хэрэгжих нийт 49 төсөл, арга хэмжээнээс 39 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байрны бичиг хэргийн зардал 10 дугаар сарын 24-ны байдлаар 23,452,088.0 төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардалд 11,327,235.0 төгрөг, Шуудан, холбоо, интернетийн төлбөрт 15,611,570.69 төгрөгийг зарцуулагдаад байна.

Яамны хөрөнгө оруулалтын 2017 оны жилийн эцсийн, 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж, сайдын багцын тайланд нэгтгүүлсэн. Үндэсний аудитын газраар шалгуулан зөрчилгүй дүгнэлт авсан. 2018 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 34 төсөл, арга хэмжээний 24,822.3 сая төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу гүйцэтгэгчийн дансанд олгосон. Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалтын ажлын төлөвлөгөө

батлагдаж, гүйцэтгэгч нартай 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу урьдчилгаа 30% буюу нийт 5,579.9 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг олгосон. 17,005.1 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж, нийт 17,005.1 сая төгрөгийн санхүүжилтийг авто замын зам, засвар арчлалтыг гүйцэтгэгч нарт олгоод байна. Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу 25 төсөл, арга хэмжээний 8,422.1 сая төгрөгийн баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу чөлөөлж, гүйцэтгэгчийн дансанд олгосон.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст сар бүр тогтсон хугацаанд нийгмийн даатгалын тайланг гарган тушааж байна. Албан хаагчдын жирэмсний тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тооцоог гаргаж, нийгмийн даатгалын хэлтсээс нэхэмжлэн, дансанд орсон тухай бүр албан хаагчдад тооцож олгож байгаа болно. 10 дугаар сарын 24-ний байдлаар нийт 18,035,114.0 төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг тооцсоны дагуу 41 албан хаагчид олгосон.

1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:

Дараах чиглэлээр 2018 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав. Үүнд:

- УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгаврын биелэлт
- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт
- Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт
- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний биелэлт
- Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт
- Яамны үйл ажиллагааны болон хүний нөөцийн бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийн биелэлт
- Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2016-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан санамж бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
- Зам, тээврийн хөгжлийн яамны дотоод бүтцийн нэгжүүдийн дарга/менежер/ нарын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт
- Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт зэрэг болно.

1.6. Хяналт шалгалтын талаар:

Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн удирдамжийн дагуу Төр хувийн хэвшил, Концессын гэрээ болон Улсын төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний зам барилгын ажлын гүйцэтгэл, батлагдсан зураг, төсөл, норм стандартын дагуу гүйцэтгэж буй эсэх, холбогдох хууль тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, дүрэм, норм,

стандартын хэрэгжилтийг шалгах, дуусаж байгаа авто зам барилгын ажлын нээлтийн бэлтгэл ажлыг хангуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай арга хэмжээ авах чиглэлээр 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс Ажлын хэсэг ажиллаж байна.

Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 314 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Хөвсгөл аймгийн Ханх-Монд чиглэлийн 23 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг шалгаж, 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 07/03/18 дугаартай дүгнэлтээр байнгын ашиглалтад оруулав.

ТНБД-ын баталсан 2018 оны 10 дугаар сарын 17-ны 38-07-003/055 дугаартай Зөвлөн туслах үйлчилгээ хийх тухай удирдамжийн дагуу 2018 оны 10 дугаар сарын 22-29-ний өдрийн хооронд МХЕГ-тай хамтран улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэгч "БСОД" ХХК /Да.Шарын гол/, "Зэлтэрийн зам" ХХК, "Шар зам ирээдүй" хоршоонд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, зөвлөмж хүргүүлсэн.

Төмөр замын цагдаагийн газраас ирүүлсэн 1 гомдол мэдээллийг хүлээн авч, 1803000186 дугаартай зөрчлийн хэрэг нээн шалгаж 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 14.10 зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу торгох шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн.

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар:

Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх нийт 16 журмын төслийг боловсруулах ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 дүгээр тушаалаар байгуулсан. Дээрх журмуудаас 1 журмын төсөл буюу "Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдалд үзлэг, шалгалт хийх, үр дүнг боловсруулах журам"-ыг батлуулах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд нийт 15 журмын төсөл боловсруулах ажлын явц 10 дугаар сард дараах байдалтай байна. Үүнээс 8 журам батлагдаж, 6 журам батлагдах шатандаа, 2 журмын төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

Автотээврийн тухай хууль шинэчлэн батлагдахтай холбогдуулан хуулийн төсөлд яамдаас санал авч эцэслэн боловсруулав. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 01/5080 тоот албан бичгээр хүргүүлэв.

Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн эцсийн найруулгын төслийг Захиргааны ерөнхий хуультай уялдуулан батлуулахад бэлэн болгоод байна.

2.2. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар:

"Түмдэлгэрэх" ХХК-аас Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдуулан Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2018 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр гаргасан "Баян-Өлгий аймгийн авто замын өргөтгөл, шинэчлэлт 10.4 км" авто замын барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн шалгаруулалтыг хууль бус болохыг тогтоолгож, сонгон шалгаруулалтыг хүчингүй болгох" тухай нэхэмжлэлд хууль зүйн үндэслэл бүхий хариу тайлбар боловсруулж 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 03/4561 тоот албан бичгээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн.

“Ашид арвин буян” ХХК-ийн нэхэмжлэлтэй Засгийн газарт холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралд 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, эвлэрлийн гэрээ байгуулах талаар тохиролцов.

“Домогт угсаа” ХХК-ийн “Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлын хурдны замтай давхцалтай газрыг чөлөөлөх тухай” нэхэмжлэлтэй хариуцагч Нийслэлийн засаг дарга, Нийслэлийн авто замын газар, Хан-Уул дүүргийн засаг даргад холбогдох захиргааны хэрэгт гуравдагч этгээдээр анхан шатны шүүх хуралд 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, нотлох баримт бүрдүүлэх хүсэлтийн дагуу хойшлогдов.

“Нүхт тур” ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газар, Үндэсний хөгжлийн газарт холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 09 цагт хуралдаж “Нүхт тур” ХХК-ийн гаргасан нэхэмжлэлийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.14-т заасны дагуу нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны хэлэлцээрийн “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орох асуудлыг хэлэлцэн соёрхон баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэлээр “Олон улсын төмөр замын тээврийн зорчигч, тээш, ачаан тээшийг хилийн боомтоор нэвтрүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах тухай конвенц”-ийн төслийн хэлэлцээ хийх зөвшөөрлийг Зам, тээврийн хөгжлийн сайдад олгосон.

Монгол Улсын ерөнхий сайд У.Хүрэлсүх Сэлэнгэ аймаг дахь газар тариалангийн бүс нутагт ажиллах үедээ Хүдэр сумын Хазай бригад, Шандын давааны авто замыг яаралтай засварлуулах чиглэл өгсөн бөгөөд Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар уг зам, давааг засварлахад зориулж Засгийн газрын нөөц сангаас 172.1 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн. Засгийн газрын шийдвэрийн дагуу дээрх зам, давааг засварлахаар 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн “Сэлэнгэ-А33А” ТӨХК ажиллаж, засварын ажлыг дуусгаад байна.

“Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого батлах тухай” бодлогын баримт бичгийг Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын 2014 оны “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай” 64 дүгээр тогтоолд нэмэлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн.

УИХ-ын 2018 оны намрын ээлжит нэгдсэн чуулганаар 10 дугаар сард “Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн УИХ-ын тогтоолын төсөл”-ийг анхны хэлэлцүүлэх жагсаалтад

оруулсан бөгөөд энэ сарын 25, 26–ны өдрүүдэд хэлэлцүүлэхээр холбогдох материалыг бэлтгээд байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 166 дугаар захирамжаар "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал"-ын үйл ажиллагааг эхлүүлж, ашиглалтад оруулахад тулгамдаж байгаа асуудлыг судалж, шийдвэрлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.

"Автотээврээр олон улсын хэмжээнд ачаа, зорчигч тээвэрлэх тухай" Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд саналыг авахаар 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 01/4741 тоот албан бичгээр яамдад хүргүүлж, холбогдох саналыг авав. Уг хэлэлцээрийн төсөлд газрын үсэг зурах эрхийг авахаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

"Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн үзэглэсэн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Гадаад харилцааны яаманд ЗТХЯ-ны 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 01/5022 тоот албан бичгийг хүргүүлсэн.

"Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан Засгийн газрын гишүүдээс саналыг авч, холбогдох саналуудыг тусган "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 31 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 5-2/6619 тоот албан бичгээр Сангийн яамнаас ирүүлсэн.

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

4.1. Авто замын талаар:

Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх авто замын салбарт хэрэгжиж буй ажлууд цаашдын бодлого, төлөвлөлтийн талаар мэдээлэл хийхтэй холбогдуулан 2018 онд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд, цаашид хэрэгжүүлэх ажлууд, баримтлах бодлогын талаар танилцуулга, мэдээлэл боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Улсын Их Хурлын чуулганд танилцуулсан.

Ажлын явц нь батлагдсан график төлөвлөгөөнөөс хоцрогдолтой буюу удаашралтай байгаа авто зам, гүүрийн барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг тодотгон шинэчлэн баталж, гүйцэтгэгч компани шинэчлэн батлагдсан төлөвлөгөөний дагуу барилгын ажлыг хийж гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Үерийн улмаас эвдэрсэн олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийг сэргээн засварлах тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 214, ургац тээврийн болон улсын чанартай авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс гарсан эвдэрлийг яаралтай засварлах тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 213 дугаар тушаалыг батлуулсан.

Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн 2018 оны урсгал засвар арчлалтын ажлын төлөвлөгөөний биелэлт 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 92%-тай хэрэгжиж байна. Урсгал засвар, арчлалтын ажлын хэрэгжилтэд "Зам,

тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ болон яамны бүс нутаг хариуцсан мэргэжилтэнгүүд хяналт тавин ажиллаж байна.

Ургац хураалтын ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний талаар гаргасан албан даалгаврын дагуу дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжуудыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 38 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу зам хариуцагч байгууллагуудаар засварлуулж улсын хэмжээнд ургац тээвэрлэлтийг саадгүй нэвтрүүлж, авто замын бэлэн байдлыг хангуулан ажиллаж байна.

4.2. Автотээврийн талаар:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангах стратеги, хөтөлбөр батлах тухай тогтоолын төсөл, хавсралт, холбогдох судалгааны хамт боловсруулж, 2018 оны 11 дүгээр сарын 6-нд холбогдох байгууллагуудыг оролцуулан хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

Стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглох, нийтийн тээвэрт ашиглагдаж буй бүх автобусанд өртөг багатай, чанар сайтай шүүлтүүр суурилуулах ажлыг зохион байгуулах, цахилгаан тээврийн хэрэгсэл түүний сэлбэг эд ангийг Гааль, НӨАТ-ын албан татвараас чөлөөлөх талаар Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2018 оны 18/03-01 дүгээр тогтоолыг гаргуулав.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн өмчит зорчигч тээврийн их багтаамжийн 319 автобусанд “DPF” шүүлтүүрийг нэмж суурилуулах асуудлыг Япон Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Төслийн бус буцалтгүй тусламж”-д хамруулах талаар судлан үзэж, шийдвэрлэж өгөхийг хүсч Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 02/5059 тоот албан бичгийг Япон Улсын Элчин сайдад хүргүүлэв.

Нийслэл хотын авто замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах зорилгоор “Нарантуул” олон улсын худалдааны төвөөс хот хоорондын зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж байгаа чиглэлүүдийг Баянзүрх, Сонгинохайрхан зорчигч тээврийн автобуудлуудад энэ оны 11 дүгээр сараас эхлэн нүүлгэн шилжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох ажил үйлчилгээг “Нийслэлийн тээврийн газар”-т шилжүүлэх шийдвэрийг Зам, тээврийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 224 дүгээр тушаалаар батлуулсан.

4.3.Төмөр замын талаар:

“Монгол-Тяньжины Дунзян тээвэр, логистикийн төв” төслийн хамтын ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээрт 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол талыг төлөөлж Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цэнгэл, БНХАУ-ыг төлөөлж Тяньжин хотын Хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ван Вейдун, “Тяньжин порт групп” ХХК-ийн ТУЗ-ын дарга Жан Руйган нар гарын үсэг зурав.

УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, А.Ундармаа Ж.Эрдэнэбат нартай хамтран Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2018 оны дугаар 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Төмөр замын хөгжил, салбарын

ажилтнуудын нийгмийн асуудал” сэдэвт зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайд 2018 оны 07 дугаар сарын 23-нд баталсан. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй хамтран “Хамтын ажиллагаа-2018” зөвлөгөөнийг 2018 оны 10 дугаар сарын 18-нд амжилттай зохион байгуулсан.

Японы буцалтгүй тусламжаар баригдсан Төмөр замын шилжүүлэн ачих байгууламжийн дэргэдэх 60 айлын 5 орон сууцыг үлдэгдэл өртгөөр хувьчлах тухай Засгийн газрын 2017 оны 245 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар Сайншандын орон нутгийн өмчийн газрын даргатай уулзах, хувьчлах үйл ажиллагаа Орон сууц хувьчлах тухай хууль мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу явагдсан эсэхийг шалгаж холбогдох дүгнэлтийг гаргасан.

БНХАУ-ын “Си Эс Ар” корпорациас нийлүүлэгдсэн хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, ашиглалтын асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 223 тоот тушаалаар батлуулсан.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал, Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан “Ази тивийн далайд гарцгүй хөгжиж байгаа зарим орны эдийн засгийн бүтцийн өөрчлөлт ба экспортын төрөлжүүлэлтийг дэмжих бүс нутгийн семинар”-т далайд гарах Монгол Улсын боломжийн талаар санал солилцож оролцов.

4.4. Агаарын тээврийн талаар:

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл болон менежмент төслийн ажлын явцын талаар тус яамны зүгээс Монгол Улсын Ерөнхий Сайдад 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдөр танилцуулж чиглэл авсан.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 102 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг Япон консорциумтой 2018 оны 10 дугаар сарын 18-31-ний өдрүүдэд концессын гэрээнд тулгарч буй асуудлуудын талаар хэлэлцээ хийж зарим асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд хэлэлцээ үргэлжилж байна.

Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 249/233 дугаар хамтарсан тушаалаар Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Хэнтий аймгийн “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог батлав.

Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр БНАЛАУ-д хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажлын хүрээнд албан захиалгат нислэгийн зарим төлбөр, хураамжийг чөлөөлөх асуудлаар Лаос улсаас Монгол Улсад суугаа элчин сайд болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн хүсэлтийг, холбогдох мэдээлэл, саналын хамтаар Иргэний нисэхийн ерөнхий газарт 2018 оны 10 дугаар сар 31-ний өдрийн 09/5253 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Төрийн өмчийн төлөөлөгчийг шинэчлэн томилох тухай” 236 дугаар тушаалаар “Хөшигийн хөндийн НОБ” ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлд Зам, тээврийн хөгжлийн яамыг төлөөлөх Төрийн өмчийн төлөөлөгчдийг шинэчлэн томилсон.

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизов, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шин Хаймин, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Масато Такаока нарыг тус тус хүлээн авч уулзаж хоёр талын зам, тээврийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр санал солилцсон.

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар Тяньжин хотын Хөгжил, шинэчлэлийн хорооны даргыг хүлээн авч уулзаж, Монгол-Тяньжины Дунзян тээвэр, логистикийн төв төслийг хэрэгжүүлэх талаар санал солилцсон.

Монгол-Тяньжины Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хоёр талын ажлын хэсэг 2018 оны 10 дугаар 23-ны өдөр Улаанбаатар хотноо Монгол-Тяньжины Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Монголын талын ажлын хэсэг, Тяньжин талын ажлын хэсэг, “Монголын төмөр зам” ТӨХК болон “Тяньжин порт групп” ХХК хоорондын Монгол-Тяньжины Дунзян тээвэр, логистикийн төв төслийн хамтын ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурсан.

ЗУРГАА. УУЛЗАЛТ, ӨДӨРЛӨГ БОЛОН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР

Азийн бүсийн орнуудын Засгийн газар хоорондын “Байгаль орчинд ээлтэй тогтвортой тээвэр-БОЭТТ” 11 дэх удаагийн олон улсын чуулга уулзалтыг Улаанбаатар хотод 2018 оны 10 дугаар сарын 2-ноос 5-ны өдрүүдэд “Тогтвортой хот байгуулалт, хот төлөвлөлтөд байгаль орчинд ээлтэй тээврийн гүйцэтгэх үүрэг” сэдвийн дор Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Япон Улсын Байгаль орчны яам, НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын нийгэм, эдийн засгийн комисс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Бүсийн хөгжлийн төв хамтран амжилттай зохион байгууллаа.

Энэхүү чуулга уулзалтын үндсэн санаа, агуулга нь Азийн орнуудын Засгийн газрын төлөөллүүд, олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын төлөөллүүд нэг дор чуулж, Азийн хотуудад тулгарч байгаа хурдацтай хотжилт, зам, тээвэр, дэд бүтцийн хүртээмжийн хомсдол, замын осол, эндэгдэл, агаар, ус, хөрсний бохирдол зэрэг үүсч буй бодит асуудлуудыг байгаль орчинд ээлтэй, тогтвортой хот төлөвлөлт, хот байгуулалт, зам, тээврийн ямар ямар шийдлээр зохицуулах талаар хэлэлцэн шийдвэр гаргах явдал байлаа. Түүнчлэн улс орнууд НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудаас гаргасан “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030”, “Хотын шинэ хөтөлбөр Хабитат III”, “Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Парисын хэлэлцээр”, “Бангкок Тунхаглал-2020” зэрэг олон улсын томоохон баримт бичигт тусгагдсан зорилтуудын хэрэгжилт, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд өөрсдийн боломж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдээс танилцуулан, хэлэлцүүлж, хурлын тэмдэглэлд тусгуулан батлав.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ